



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025-2028 он

Төлөвлөгөөг баталсан:

Аймгийн Засаг дарга

(албан тушаал)

Тэмдэг

.....

(гарын үсэг)

Төсвийн Ерөнхийлөн захирагч

/Б.Зоригтбаяр/

(огноо)

.....

Төлөвлөгөө боловсруулсан:

Эрүүл мэндийн газрын дарга

(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн шууд захирагч

/Ц.Мөнхцэцэг /

.....

(гарын үсэг)

(огноо)

.....

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Оршил
- 1.2 Үндэслэл

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

ГУРАВ. ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

- 3.1. SWOT шинжилгээний нэгтгэл
- 3.2. PESTEL шинжилгээний нэгтгэл

ДӨРӨВ. ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 4.1. Алсын хараа
- 4.2. Эрхэм зорилго
- 4.3. Баримтлах зарчим
- 4.4. Хэрэгжүүлэх хугацаа

ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, БА ЭМГ-ЫН БҮТЭЦ, САЛБАР БАЙГУУЛЛАГЫН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

- 5.1 СТРАТЕГИЙН ЗОРИЛГО
- 5.2 ЭМГ-ЫН БҮТЭЦ, САЛБАР БАЙГУУЛЛАГУУДЫН ЗУРАГЛАЛ

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

ДОЛОО. СТРАТЕГИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

НАЙМ. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЗДТГ- Засаг даргын тамгын газар
ААНБ- Аж ахуй нэгж байгууллага
БОЭТ-Бүсийн оношилгоо эмчилгээний төв
БТСГ- Биеийн тамир спортын газар
НДХ-Нийгмийн даатгалын хэлтэс
НБХ-Нийгмийн бодлогын хэлтэс
НЭМТ-Нийгмийн эрүүл мэнд төв
НҮЭМ-Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ОУБ- Олон улсын байгууллага
ОБГ- Онцгой байдлын газар
ТБ-Төрийн байгууллага
ТББ-Төрийн бус байгууллага
СЭМТ-Сумын эрүүл мэндийн төв
ӨЭМТ-Өрхийн эрүүл мэндийн төв
УЗХ-Улаан загалмайн хороо
ХХЭМБ-Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
ХЭАН-Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг
ЭМЯ-Эрүүл мэндийн яам
ЭХЭМҮТ-Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМГ-Эрүүл мэндийн газар
ЭМБ-Эрүүл мэндийн байгууллага
ЭХНБ-Эм ханган нийлүүлэх байгууллага
ЭМС-Эрүүл мэндийн салбар

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Эрүүл мэндийн газар (цаашид “газар” гэх)-ны үйл ажиллагааны стратеги нь Эрүүл мэндийн газрын дарга (цаашид “дарга” гэх)-ын болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нэмэгдүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийг оновчтой төлөвлөх, салбар нэгжийг удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнтэй, бодитой төлөвлөлт хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, бодлого боловсруулах асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийг тодорхойлоход чиглэгдсэн. Төрийн албаны тухай хуулийн 53.1 дэх хэсэгт “ Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасны дагуу энэхүү стратеги төлөвлөгөө нь Эрүүл мэндийн газрын 2025-2028 онд баримтлах дунд хугацааны хөгжлийн стратегийн үндсэн баримт бичиг болно.

1.2. Стратеги төлөвлөгөөний үндэслэл

Өнөөгийн байдлаар салбарын хэмжээнд урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тулгуурлан хэрэгжүүлж байна.

Нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалах үүрэг нь нийтийн эрүүл мэндийн дэмжиж өвчилсөний дараа бус харин өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх, иргэдийг өөрөө өөрийгөө хамгаалхуйц эрүүл мэндийн боловсролтой болгож, эрүүл чийрэг бие бялдартай, зөв зан үйлтэй, саруул оюун ухаантай, амьдралын зөв хэвшил бүхий эрүүл орчинг бүтээгч эрүүл хүнийг бий болгоход эрүүл мэндийн салбарын ойрын болоод холын хөгжлийн бодлого оршиж байна.

2024 онд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль батлагдаж дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд эрх зүйн орчинг бүрдүүлэхээс гадна, 2024 оны УИХ-ын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр,

Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний зорилтуудад эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийх, хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх дэд төвийг бүс бүрт байгуулахаар тусгаж оруулсан байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд төвлөрлийг сааруулахад салбарын бодлого чиглэж, үндэсний багуудыг орон нутагт ажиллуулж, орон нутагт шинэ дэвшилтэт технолого, аргыг нутгалшуулан, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулан, бүс нутгаасаа гаралгүйгээр эрүүл мэндийн тусламж авдаг болохоор зорьж байна.

Үүнийг төлөвлөн хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн газар нь үндсэн байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх, байгууллагын хөгжлийг хангах, иргэдийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, аргачлал, загвар”-ын хүрээнд уг төлөвлөгөөг боловсрууллаа.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчим:

- Бодлогын залгамж чанарыг хадгалсан, нэгдмэл, харилцан уялдаатай
- Хүний эрүүл мэндийг дэмжсэн, эрүүл иргэн бий болгоход нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний уялдааг хангасан
- Стратегийн зорилт арга хэмжээний үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх
- Шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшин нь хэрэгжих боломжтой, тоон болон чанарын утгаар илэрхийлэгдсэн, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх
- Бодлогын баримт бичгийг боловсруулахад судалгаа, шинжилгээ, нотолгоонд тулгуурласан байх

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тусламж үйлчилгээний үзүүлэлт, тулгамдсан асуудлууд:

Орхон аймаг нь нийт 105 мянга 269 хүн амтай бөгөөд засаг захиргааны хувьд 2 сум, 29 багтай. Аймгийн хүн амын дундаж наслалт 73.34 байна. Нийт хүн амын 49.1 хувийг эрэгтэйчүүд, 50.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж, насны бүтцийн хувьд нийт хүн амын 31.5 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 63.3 хувийг 15-64 насны, 5.2 хувийг 65-аас дээш насны хүн ам эзэлж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 161 нэгжид 474 их эмч, 512 сувилагч, эм зүйч 145, эх баригч 33, бага эмч 77 нийт 2089 ажиллаж иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүллээ.

Эрүүл мэндийн ажиллагчдын дийлэнх нь буюу 1805 (86.4%) нь эмэгтэйчүүд, 284 (13.6%) нь эрэгтэйчүүд байгаа ба 2023 онд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 87.0 хувь 2024 онтой харьцуулахад 0.6 хувиар буурсан байна. Нийт эмч, эмнэлгийн ажилтны 24.5 хувь нь мэргэжлийн зэрэгтэй, эмч нарын 88 хувь, сувилагч нарын 60 хувь нь нарийн мэргэжил эзэмшсэн байна. 10 000 хүн амд их эмч 45, сувилагч 49 ногдож, эмч сувилагчийн харьцаа 1:1:18 байна.

: 2024 оны байдлаар 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 19.0 промилл болж өмнөх онтой харьцуулахад 2.0 промиллоор буурч, нас баралт 5.0 промилл байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.4 промиллоор нэмэгдэж, хүн амын цэвэр өсөлт 14.0 промилл болж 2.4 промиллоор буурсан нь улсын дундажтай харьцуулахад төрөлт, хүн амын цэвэр өсөлт улсын дунджаас дээгүүр, нас баралт буурсан үзүүлэлттэй байна. Жирэмсний эрт үеийн хяналт 99.2 хувьд хүрч, сүүлийн 6 жил эхийн эндэгдэлгүй ажилласан.

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд сүүлийн жилүүдэд амьсгалын тогтолцооны өвчлөл, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, шээс бэлэгсийн тогтолцооны өвчлөл, цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл, бэртэл хордлого ба бусад гадны шалтгааны үр дагаврууд нэмэгдэх хандлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд 769 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 73.1 ногдож өмнөх оны мөн үеэс 302 тохиолдлоор буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 27.7 промиллоор буурсан. Халдварт өвчний бүтцийг харахад нийт халдварт өвчний 36.0 хувийг амьсгалын замын халдвар, 35.5 хувийг арьсны халдвар, 19.6 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 8.2 хувийг гэдэсний халдвар, 0.5 хувийг цусаар дамжих халдвар тус тус эзэлж байна.

Хүн амын нас баралтын 35.4 хувийг зүрх судасны тогтолцооны өвчин, 31.2 хувийг хорт хавдар, 6.5 хувийг бэртэл хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар эзэлж байна. Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр нас барсан 3 хүн

тутмын нэг нь зүрх судасны тогтолцооны өвчнөөр, 3 хүн тутмын нэг нь хорт хавдрын улмаас, 7 хүн тутмын нэг нь гэмтэл, хордлого, гадны шалтгааны улмаас нас баржээ.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2024 онд 1000 амьд төрөлтөд 10.4 промилл байгаа нь Тогтвортой хөгжлийн зорилтын I шатны хүрэх түвшин (12 промилл)-өөс 1.6 промиллоор, нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 9.9 промилл байгаа Тогтвортой хөгжлийн зорилтын I шатны хүрэх түвшин (11промилл)-өөс 1.1 промиллоор бууруулсан амжилттай ажилласан байна.

Нялхсын эндэгдлийн 85 хувийг перинаталь үеийн эмгэг эзлэж, эндэгдлийн түвшин өмнөх оноос 4.3 промиллоор, улсын дунджаас 2.5 промиллоор өндөр байгаа нь энэ тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд шинээр 324 хорт хавдрын өвчлөл бүртгэгдэж 10000 хүн амд 30.8 промилл, 191 нас баралт бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 68 тохиолдлоор өссөн.

Сүүлийн 3 жилд хорт хавдраар өвчлөгчдийн тоо жил тутам дунджаар 1.4 дахин нэмэгдэж байгаа нь нэг талаас хорт хавдрын эрт илрүүлэг сайжирсан үр дүн харагдаж байгаа боловч цаашид хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болох хандлага мөн ажиглагдаж байна. Иймд хорт хавдар өвчний тусламж үйлчилгээг сайжруулах, эрт үед нь илрүүлэх, нас баралтыг бууруулах, орон нутагт нь эмчлэх цогц тусламж үйлчилгээг үзүүлэх нь нэн чухал болоод байна.

Мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэн ч эрүүл мэндийн байгууллагуудад нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй хэрэгжиж байгаа нь урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал болж байна.

Цаашид хүн амд хүрч үйлчлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, төвлөрлийг сааруулах, орон нутагтаа оношлох, эмчлэх цогц үйлчилгээ үзүүлэх чадавх болон эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулан Бүсийн нутгийн хэмжээнд тусламж үйлчилгээг тэргүүлэн үзүүлэх шаардлагатай байна.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу салбарын чиг үүргийн мандатыг 2025 онд хийсэн. “Чиг үүрэг” гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэлийг хэлнэ гэж заасан байна.

Уг мандатын шинжилгээгээр Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль, бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй дүрэм, журмын хүрээнд “Мандатын шинжилгээ”-г хийж эрүүл мэндийн салбарын чиг үүргийг Ерөнхий 1, үндсэн 6, дэд 18, хамтран хэрэгжүүлэх 47 чиг үүргийг тодорхойллоо.

Хүснэгт 1. Хуулийн жагсаалт

Нийтлэг мөрдөгддөг хууль	Чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа хууль
1. Монгол Улсын Үндсэн Хууль 2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 3. Төрийн албаны тухай хууль 4. Төсвийн тухай хууль 5. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 6. Захиргааны ерөнхий хууль 7. Хөдөлмөрийн тухай хууль 8. Зөрчлийн тухай хууль 9. Татварын тухай хууль	1. Эрүүл мэндийн тухай хууль; 2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай 3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль; 4. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 5. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 6. Зөвшөөрлийн тухай хууль 7. Жендерийн эрх тэгш байдлын тухай 8. Хүүхэд хамгааллын тухай хууль 9. Статистикийн тухай хууль 10. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль 11. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай 12. Ахмад настны тухай хууль 13. Дархлаажуулалтын тухай хууль 14. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай 15. Ахмад настны тухай хууль 16. Дархлаажуулалтын тухай хууль 17. Хог хаягдлын тухай хууль 18. Орчны эрүүл мэндийн тухай хууль 19. Архив, албан хэрэг хөтлөлтийн

	тухай хууль 20. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
--	---

Хүснэгт 2. Салбарын чиг үүрэг

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		60
үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	20
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	40
Ерөнхий чиг үүрэг-1. Байгууллагын чадавхийг бэхжүүлэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн ажиллагсдыг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангаж ажиллахад эрүүл мэндийн байгууллагуудад бүх талын дэмжлэг үзүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, иргэдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ	АЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага Олон улсын байгууллага Эрүүл мэндийн байгууллагууд Аж ахуйн нэгж байгууллага Иргэд
	Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсэж байгаа хүчин зүйлсийн бууруулах, иргэдийн эрүүл мэндийн хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хоололтыг дэмжинэ	
	“Эрүүл шүд”, “Хорт хавдараас сэргийлэх, хяна”, зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл амьдарлын хэв маягийг төлөвшүүлнэ.	
	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогцоор үзүүлэх төвийг байгуулна.	
ҮЧҮ-2: Эмнэлгийн тусламж үйлчилгээ	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, төвлөрлийг сааруулах, зарим тусламж үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулж орон нутагтаа оношилох, эмчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	ЭМЯ, Эрүүл мэндийн байгууллагууд, ЗДТГ, НБХ, Улсын 1, 2, 3 лавлагаа шатлалын эмнэлгүүд Олон улсын байгууллага
	Эх хүүхэд, зорилтот бүлэгт үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний	

	чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	
	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	
	Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн, хөгжүүлж, иргэдэд урт болон богино хугацаагаар цогц байдлаар тусламж үйлчилгээг үзүүлнэ.	
	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулна.	
ҮЧҮ-3: Хүний нөөцийн хөгжил	Орон нутагт эмчлэх оношлох зорилгоор Үндэсний багуудыг ажиллуулж, хүний нөөцийг чадавхжуулна.	ЭМЯ, ЭМХТ, Улсын 1, 2, 3 лавлагаа шатлалын эмнэлгүүд, БОЭТ, ЭМБ-ууд,
	Эрүүл мэндийн ажилтаны нийгмийн баталгааг сайжруулж, төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодоо сургах, туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	
ҮЧҮ-4: Эрүүл мэндийн салбарын мэдээлэл, технологийн удирдлага	Иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамраан авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемидицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлэх	ЭМЯ, ЭМХТ, Цахим хөгжлийн яам, ЭМБ-ууд, Олон улсын байгууллага
	Цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэгтгэн уялдуулж, үр ашгийг дээшлүүлнэ.	
ҮЧҮ-5: Эрүүл мэндийн санхүүжилт	Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг тусламж үйлчилгээтэй уялдуулан, оновчтой хийж, гүйцэтгэлд хяналт хийх, үр дүнг тооцох тогтолцоог хэрэгжүүлнэ.	АЗДТГ, ЭМЯ, Олон улсын байгууллага Эрүүл мэндийн байгууллагууд Аж ахуйн нэгж байгууллага Төрийн бус байгууллага
	Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	
ҮЧҮ-6: Эрүүл мэндийн салбарын удирдлагын манлайлал, ил тод байдал	Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулна.	АЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага Олон улсын байгууллага
	Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, эрүүл мэндийн	

	байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлнэ.	Эрүүл мэндийн байгууллагууд
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн эгэх хариуцлагыг нэмэгдүүлнэ.	Аж ахуйн нэгж байгууллага Иргэд

Эрүүл мэндийн газар нь хууль тогтоомжоор олгогдсон үндсэн чиг үүрэг, түүнд нийцүүлэн тодорхойлсон эрхэм зорилгоо хангахад чиглэгдсэн 2025-2028 онуудад баримтлах стратегийн зорилтыг дэвшүүлж байна. Аймгийн Эрүүл мэндийн газрын стратегийн зорилтыг тодорхойлохдоо ЭМГ-ын өнөөгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай уялдуулсан болно.

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ
3. Хүний нөөцийн хөгжил
4. Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага
5. Эрүүл мэндийн санхүүжилт
6. Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал

ГУРАВ. ДОТООД, ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол улсын болон орон нутгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тавьсан зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлыг төлөвлөлтийн баримт бичигт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх зорилгоор салбарын өнөөгийн нөхцөл байдалд гадаад, дотоод орчны талаарх мэдээллийг цуглуулж, SWOT шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

3.1 SWOT шинжилгээний нэгтгэл

Дотоод орчны шинжилгээ	
Давуу тал	Сул тал
- Орхон аймгийн 2024-2028 оны хөгжлийн стратеги төлөвлөгөө батлагдсан. - Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг батлан гаргасан. - Аймгийн засаг даргын үйл ажиллагааны 2024-2028 оны хөгжлийн хөтөлбөр батлагдсан.	- Олон стандарт, дүрэм, журам байгаа боловч стандартын хэрэгжилтийн хувь бага. - Шинээр гарсан бодлогын баримт бичгийг сурталчлах, таниулах, мөрдөж ажиллах хангалтгүй. - Албан хэрэг хөтлөлтийн стандарт хангалтгүй.

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлсэн. - Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. - ЭМС, АЗД-тай хийсэн 2025 оны гэрээ байгуулагдсан. - Эрүүл мэндийн байгууллагууд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлж байна. - “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” батлагдсан. - Дэвшилтэт технологи нэвтрүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад болон дотоодын сургалтад хамруулж, чадавхыг нэмэгдүүлсэн. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Зүрхний шигдээс, ангиографийн нэгж болон Хавдарын оношилгоо, эмчилгээ сэргийлэлтийн төв нээгдсэн. - Төвлөрлийг сааруулахаар Үндэсний багуудыг орон нутагт ажиллуулж, шинэ дэвшилтэт технологи, аргыг нутагшуулж байна. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дэргэд сургалтын албатай /төгсөлтийн дараах үндсэн мэргэшил, сувилахуйн төрөлжсөн мэргэшил олгох/ - 7 ӨЭМТ-үүд стандартын шаардлага хангасан байртай. Тоног төхөөрөмжийн хангалт 100 хувьд хүрсэн. - Хувийн хэвшлийн эмнэлгүүд өндөр хүчин чадалтай багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. - Шинэ сувилагчийг дадлагжуулах хөтөлбөр хэрэгжиж байна - Хүн амын 96 хувь аймгийн төвдөө төвлөрсөн. - Өрхийн эрүүл мэндийн төвүүд urh.mn сайт руу шилжсэн. - Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллагууд хэрэгжүүлж, хэрэгжилт 87%-тай байна.	- Төлөвлөгөөг оновчтой гаргахгүй, хэрэгжилтийг тооцохгүй байна. - Байгууллагын дотоод хяналт тогтмолжоогүй, үр дүнг тооцсон байдал хангалтгүй. - Олон цахим програмтайгаас болж ажлын ачаалал их, давхцал их үүсэж байна. - Эмнэлгүүдийн цахим програмаар мэдээлэл дамжуулах, хугацаанд нь ирүүлэх байдал алдагддаг. - Интернэтийн мэдлэг муу, компьютерийн хүчин чадал хангалтгүйгээс хэрэглээний програм дээр ажиллахдаа удаан байна. - Хүний нөөцийн хомсдол үүсч байна. - Сургаж, мэргэшүүлсэн боловсон хүчнээ тогтвор суурьшилтай ажиллуулж чадахгүй байна. - Цалин хангамж, урамшууллын тогтолцоо сул. - Иргэдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, дадал, хандлага муутайгаас ор шүтсэн уламжлалт ойлголт хэвээр байна. - Дээд шатны байгууллага, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоо муу - Нийгмийн эрүүл мэндийн ажилтануудын чадавх сул - Эрүүл мэндийн байгууллагуудад нийгмийн эрүүл мэндийн ажилтан орон тоогоор ажиллахгүй байгаагаас нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй хэрэгжиж байна. - Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт цаг үеэ даган өөрчлөгдөхгүй, эмнэлгүүдэд магадлан итгэмжлэлд хамрагдахад хүндрэл үүсгэж байна. - Иргэдийн эмийн зохистой хэрэглээ алдагдсан, бичил биетний тэсвэржилт үүссэн, үүнээс үүдэлтэй олон эмэнд тэсвэртэй болж өвчин эдгэрэлт удааширсан. - Эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй. Үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэл алдагдах эрсдэл өндөр.
--	--

Гадаад орчны шинжилгээ	
Боломж	Эрсдэл
- Аймгийн ЗДТГ, ИТХ-ын зүгээс тухайн онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг сайн шийдвэрлэдэг. - Олон улсын төсөл хөтөлбөрөөр хөрөнгө оруулалтыг татах боломжтой. - Чадварлаг мэргэшсэн багийг бүрдүүлэх боломжтой. - Хариуцлага, урамшууллын систем нэвтрүүлэх боломжтой. - Гадаад харилцааг өргөжүүлэх, туршлага солилцох боломжтой. - Үйл ажиллагааны процессыг хөнгөвчлөх боломжтой. - Шинэлэг үйлчилгээ, орчин үеийн менежмент нэвтрүүлэх боломжтой.	- Иргэд буруу мэдээлэл авах бусдад дамжуулах, иргэд хохирох, иргэдийн сэтгэл ханамж буурах. - Интернэт, цахим сүлжээгээр эзэнгүй худал мэдээлэл тархах. - Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцаанаас шалтгаалан байгууллагын нэр хүнд унах. - Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийг эрт хугацаанд илрүүлээгүйгээс үйлчлүүлэгчийн аюулгүй байдал алдагдах - Эмийн чанар аюулгүй байдал алдагдсан /хуурамч эм/ - Хөрөнгө оруулалтаар стандартын шаардлагад нийцэхгүй тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээс тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх.

3. 2. PESTEL шинжилгээний нэгтгэл

Засгийн газрын бодлого чиглэл, хууль эрх зүйн зохицуулалт	
- Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд томоохон хуулиудыг шинэчлэн гаргаж эрх зүйн орчин хангалттай бүрдсэн. - Иргэд хууль тогтоомжийн талаар мэдээлэл авах бүрэн боломжтой. - Хууль дагасан журмуудыг батлан гаргаж байна.	- Улс орны эдийн засгийн хямралтай холбоотойгоор бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй болох, эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ буурах - Стратегийг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэргүй болох - Тендэр амжилтгүй болсноос хөрөнгө оруулалт зогсох - Гүйцэтгэгч байгууллага гэрээний хугацаанд ашиглалтад оруулаагүйгээс хөрөнгө оруулалт зогсох - Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа гол гол хуулиудад ойр ойрхон хугацаанд нэмэлт өөрчлөлт орж байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. - Тусламж үйлчилгээний төрөл, чанарыг хөшүүрэгдсэн санхүүжилт хангалтгүй - Хуулийн хэрэгжилт хангах, зохион байгуулах, тогтмол хянах хүний нөөц, чадавх хангалттай бус байгаагаас хуулт тогтоомжийн хэрэгжилт сул

	байна.
Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс	
- Хүн ам төвлөрсөн. Бусад аймаг, сумдын хөдөлгөөнт хүн ам ихтэй - Орон нутгийн эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. - Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт нэмэгдсэн.	- Хүн амын шилжилт хөдөлгөөн их - Хүн амын тоо жилээс жилд өсч байна. - Хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн хөрс, утаа орчны бохирдол их - Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар нэмэгдэж байна - Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан нь ихэвчлэн амьдарлын хэв маягаас үүдэлтэй харьцангуй сэргийлж болох нас баралт эзлэж, нэмэгдэх хандлагатай - Ахуйн хүрээний архидалт их, электорн тамхины хэрэглээ өндөр болсон - Ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. - Улс төрийн тогтворгүй байдал, эрүүл мэндийн тогтолцоонд улс төрийн оролцоо нэмэгдэх - Үнийн өсөлт - Шинэ төгсөгчдийн боловсролын чанар муу - Ажилгүй иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүй тул эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байх
Гадаад харилцаа, түншлэл	
- ДЭМБ, Жайка ОУ-ын байгууллага, Глобал сан зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг. - Гадаад улс оронд эмч, эмнэлгийн ажиллагсад уулзалт, семинарт оролцож мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлэх. - Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд төр засаг, яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх. - Олон улсын байгууллагаас төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, семинар явуулах зэргээр дэмжлэг тусалцаа авах. - Өндөр хөгжилтэй улс орнуудтай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх.	- Гадаадад тэтгэлгээр сургах боломж гарахад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн англи хэл хангалтгүй. - Хамтын ажиллагаа сайн хөгжөөгүй, санхүүгийн тусламж үзүүлэх үйл явц хангалттай хөгжөөгүй - Эрүүл мэндийн салбар нэгжүүдэд бүтээмж инновацийн үр дүнг тооцохгүй байна. - Төр хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагаанд талуудын оролцоо хангалтгүй. - Хувийн хэвшлийн ор бүхий клиникүүдийн стандарт тодорхой бус зохицуулалт хангалтгүй. - Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гэрээгээр гүйцэтгэх ажил хомс - Эрх зүйн чадамжтай төрийн бус байгууллага нийгэмлэг, холбоод орон нутагт байхгүй байна.
Технологийн хүчин зүйлс	

- Бусад хамтрагч талуудтай харилцаа холбоо тогтоох, цахим мэдээлэл солилцох боломжтой. - “Цахим эрүүл мэнд” нэгдсэн платформ хэрэгжинэ. - Urkh.mn - анхан шатны цахим нэгдсэн програм - 1313.mn болон QR кодоор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах. - HRDS-хүний нөөцийн нэгдсэн програм - License.mn-тусгай зөвшөөрлийн нэгдсэн програм - ЭМБ-ууд дотоод сүлжээ, интернетийн хурдыг нэмэгдүүлсэн. - Зайн сургалт хийгдэх нөхцөл боломжоор хангагдсан. - Телемедицинээр зөвлөгөө авах - Хиймэл оюун ухаан нэвтэрсэн /AI/ - Цахим бүртгэл, хяналт /эм, бүртгэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх үзлэг..гм/	- Мэдээллийн технологийн бэлтгэгдсэн ажилтан хангалтгүй, цөөн, ажлын ачаалал их. - Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж буй программ хангамжууд харилцан хөрвөж мэдээ солилцох явдал хангалтгүй. - Телемедициний тоног төхөөрөмж хангалтгүй. - зайн оношилгоо эмчилгээ хангалтгүй, бүртгэх, мэдээллэх үйл явц алдагдсан
---	--

ДӨРӨВ. АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, АЖИЛЛАХ ЗАРЧИМ

4.1 Алсын хараа: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн бүрт чанартай хүргэхэд оновчтой, үр дүнтэй тогтолцоог бий болгосон, Бүс нутгийн хэмжээнд манлайлагч байгууллага болно.

4.2 Эрхэм зорилго: Эрүүл мэндийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд салбарын бодлого чиглэж, хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсрол, амьдралын чанарыг дээшлүүлэн эрүүл амьдарлын хэв маягийг төлөвшүүлж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

4.4 Баримтлах зарчим:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тэргүүлэх чиглэл болгоно.
- Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл, соёл, амьдралын түвшний ялгаа зэргээс үл хамааран хэнийг ч орхигдуулахгүй байх нэгдсэн зарчимд тулгуурлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх

- Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байх
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах
- Нотолгоонд суурилсан, орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх
- Чадавхыг бэхжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх.
- Санхүүжилтийг үйл ажиллагаатай нь уялдуулан оновчтой хуваарилах.
- Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх

4.5 Хэрэгжүүлэх хугацаа: 2025-2028 он


ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, САЛБАР, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

5.1 СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор эрүүл мэндийн байгууллагын чадавхийг бэхжүүлэн гүйцэтгэлийн санхүүжилт, дэвшилтэт технологи, цахим үйлчилгээний үр ашгийг дээшлүүлсэн үр дүнтэй тогтолцооний шинэчлэлтийг хийнэ.

5.2 САЛБАР, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

2024 оны байдлаар Орхон аймагт нийт 162 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа Бүсийн оношилгоо эмчилгээний төв 1, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 1, сум, өрхийн эрүүл мэндийн төв 9, сувилал 1, хувийн хэвшлийн нэгдсэн эмнэлэг 1, ор бүхий клиник 11, клиник 56, эмийн сан 72, ЭХНБ 9, цэргийн эмнэлэг 1 тус тус ажиллаж нийт 2089 эмч, эмнэлгийн мэргэжилтэн бусад ажилтнууд байна. Аймгийн хэмжээнд 75 нийтийн үйлчилгээтэй эмийн сан ажиллаж эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр 50 эмийн /66.7% /эмийн сан иргэдэд үйлчилж байна. Нийт эмийн сангийн 46 /61.3%/ хотын төвийн байршилд, 29 /38.7%/ нь гэр хороололд байрлаж байна. Зайлшгүй шаардлагатай эмийн 10-р жагсаалтад эмийн санд байвал зохих эмийн хангамж эм ханган нийлүүлэх байгууллагуудад дунджаар 88.6%-тай болж, өмнөх оноос 0.2%-иар өссөн



Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 415 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны 413 дугаар захирамжаар 36 орон тоотойгоор Удирдлага төлөвлөлтийн хэлтэс, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн төв, Хяналт шалгалтын хэлтэс гэсэн 5 нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж, салбар нэгжүүдийг бодлогын хүрээнд мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүрэг

- Тус хэлтэс нь төрийн албаны тогтвортой байдал, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхыг бэхжүүлж, албаны өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн, чадварлаг аппарат бүрдүүлэх, эрүүл мэндийн чиглэлээрх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, салбарын үйл ажиллагааны

ил тод байдлыг хангах ажлыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хөгжүүлэх, боловсрол, мэргэжлийн зэргийг тасралтгүй дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн багц цагийн биелэлтэд хяналт тавих, эрүүл мэндийн ажилтны ажиллах нөхцөл нийгмийн баталгааг дэмжих, урамшуулах, эрүүл мэндийн салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлж, төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөн, биелэлтийг хангуулах, тайлагнах, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хэрэгцээнд дүн шинжилгээ хийх, санхүү, төсвийн ил тод байдлыг хангах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

- Тус хэлтэс нь эрүүл мэндийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, байгууллагын дотоод хяналтын багийг удирдлагаар ханган, дүгнэлт, зөвлөмж гаргах, бодлого боловсруулахад оролцох, түүнийг хэрэгжүүлэх ажилд оролцож байгаа албан тушаалтны үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, дэмжлэгээр цаг тухайд нь хангах, эрүүл мэндийн статистикийн мэдээ, мэдээллийг нэгтгэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүрэг

- Тус хэлтэс нь хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй өргөн хүрээний тусламж, үйлчилгээг үзүүлэх, бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, анхан шатны болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг хүн амд үзүүлэх, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг зохицуулах, эрүүл мэндийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Нийгмийн эрүүл мэндийн төвийн үндсэн үүрэг, чиг үүрэг

- Тус төв нь нийтийн эрүүл мэндийн чиглэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хүн амын өвөрмөц бүлгүүдийн эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурласан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, халдварт, халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах, эрүүл, аюулгүй

орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, халдварт, халдварт бус өвчлөлийн ойрын болон хэтийн төлөв, хандлагыг тодорхойлох үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, эрүүл мэндийг дэмжих, нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд нутгийн захиргааны, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог хангах, олон улсын болон салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хэвлэл мэдээлэлтэй харилцах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнөөс сэргийлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөлийн тайван цагийн бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөх, нийтийг хамарсан онцгой нөхцөл үүссэн үед ЭМЯ, ХӨСҮТ-тэй харилцах, эрсдэлийн үеийн мэдээ мэдээлэл, харилцаа холбоо, хариу арга хэмжээг зохион байгуулах, зохицуулах чиг үүрэг хэрэгжүүлнэ. Тус төвийн бүтцэд эрүүл мэндийг дэмжих, халдварт өвчний тандалт сэргийлэлтийн хэлтэс, халдварт бус өвчний тандалт, сэргийлэлтийн нэгж ажиллана.

Хяналт шалгалтын хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүрэг

- 2023 онд Мэргэжлийн хяналтын газар татан буугдаж, 2023 оноос ЭМГ-ын Хяналт, шалгалтын хэлтэс болгож, зохион байгуулалтын бүтэц шинээр нэмэгдсэн. Хэлтэс нь 2022 оны Засгийн газрын 479 дүгээр тогтоолын дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Эрүүл ахуйн халдвар хамгаалын хяналтыг орчны эрүүл ахуй, хүнсний эрүүл ахуй, хүүхдийн эрүүл ахуй, халдвар судлалын 4 чиглэл, эмчилгээ оношилгооны чанар аюулгүй байдлын 1 чиглэлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу төрийн захиргааны хяналт шалгалтын үүргийг гүйцэтгэнэ.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2024/	Хүрэх түвшин/он/				Тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж
				2025	2026	2027	2028		
1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хувь	Хувь	35.1	36.1	36.5	37.0	37.5	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
2	Жирэмсний эрт үеийн хяналт	Хувь	99.2	99.3	99.4	99.5	99.6	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа

3	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	Промилл	9.9	8.26	8.2	8.1	8.0	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
	1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	Промилл	10.4	8.26	8.2	8.1	8.0	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
4	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	Промилл	-	-	-	-	-	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
5	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10000 хүн амд	Промилл	17.6	15.5	15.2	14.9	14.7	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
6	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10000 хүн амд	Промилл	18.1	14.0	13.9	13.8	13.7	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
7	Товлолт дархлаажуулалты н хувь	Хувь	99.8	99.8	99.8	99.8	99.8	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
8	Эрсдэлт бүлгийн хүн амын сүрьеэгийн илрүүлэгт хамтруулах	Хувь	30	35	40	45	50	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
9	Бэлгийн замаар дамжих халдварын түвшин (10000 хүн амд)	Промилл	28.2	28.1	28.0	27.9	27.8	2024 оны суурь түвшин	Жилд нэг удаа
10	Эмч, сувилагчийн харьцаа	Тоо	1:1.1	1:1.5	1:1.5	1:1.8	1:2	1 эмчид ногдох сувилагч ийн тоо	Жилд нэг удаа
12	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	хувь	72.4	73%	75%	78%	80%		Жилд нэг удаа

ДОЛОО. СТРАТЕГИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

8.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ үнэлгээг нутгийн захиргааны байгууллага /Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс/ нь хоёр жил тутамд хийж дүнг Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулна.

8.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн газар нь стратегийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

--- оОо ---

НАЙМ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028 он)

Бодлогын баримт бичигт тусгагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин 2025 он	Зорилтот түвшин 2026 он	Зорилтот түвшин 2027 он	Зорилтот түвшин 2028 он	Санхүүгийн эх үүсвэр
1.Ерөнхий чиг үүргийн нэр: <i>Байгууллагын чадавхийг бэхжүүлэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн ажиллагсдыг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангаж ажиллахад эрүүл мэндийн байгууллагуудад бүх талын дэмжлэг үзүүлэх</i>								
1 –р Үндсэн чиг үүрэг: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ								
Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулж, эрүүл зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлж дундаж наслалтыг нэмэгдүүлэх	Нийгмийн эрүүл мэндийн төвийн байгуулж, цогц тусламжийг үзүүлэх	тоо	-		1			Улс, орон нутгийн төсөв
	Иргэний эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэгийг үргэлжлүүлж, хүн амыг өвчнөөс сэргийлэх, хянах хөтөлбөр хэрэгжүүлэх	Эрт илрүүлгийн хувь	35.1	36.1	36.5	37.0	37.5	Улс, орон нутгийн төсөв
	Эрүүл мэндэд эрсдэл үүсэж байгаа хүчин зүйлсийг тандан судлаж, түүнд түшиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Суурь судалгааны тоо	0	1	2	3	4	Орон нутгийн төсөв
	“Эрүүл хамт олон” ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах	Байгууллагын тоо	91	96	101	106	111	Орон нутгийн төсөв
	Сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	Тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	91	96	101	106	111	Орон нутгийн төсөв
	“Эрүүл шүд”, “Хорт хавдараас сэргийлэх, хянах”, зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр днг тооцох	Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундаж хувь	86.5%	87%	87.5%	88%	88.5%	Улс, орон нутгийн төсөв ЭМД-ын сан Олон улсын төсөл хөтөлбөр

Зорилт 2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулах	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлэх.	Эрт илрүүлэг хувь	69,4	70,6	71,8	73	74,3	Байгууллагын төсөв, ЭМД сан
	Хүн ам, ялангуяа цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их дээд сургуульд суралцагчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны хүртээмжийг дээшлүүлэх.	90%-аас бууруулахгүй байх	85%	90%	92%	93%	95%	Орон нутгийн төсөв
Зорилт 3. Агаар, ус, хөрсний бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тандаж, бууруулах эрүүл мэндийн цогц арга хэмжээг бусад салбарын дэмжлэгтэй хэрэгжүүлэх	Агаар, ус, хөрсний бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах салбар хоорондын төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%-аас дээш	83	87	90	92	Улс, орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр
	Орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1000	1500	2000	2500	3000	Орон нутгийн төсөв
Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж салбар дундын ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, үр дүнг тооцох	Төлөвлөгөөний Хэрэгжилтийн хувь	82%	84%	86%	88%	90%	Орон нутгийн төсөв
	“Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлж, гепатит вирсын халдварыг бууруулах, эмчлэх, хяналтад авах	Хяналтын хувь	30%	40%	50%	60%	80%	Орон нутгийн төсөв, ХӨСҮТ, байгууллагын төсөв
	Заавал хийх товллын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалтыг зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, тарилгатай	Дархлаажуулалтын хамралт 99,5%-иас бууруулахгүй байна.	99.5	99.6	99.7	99.8	100	Улс, орон нутгийн төсөв

	халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тандалтыг эрчимжүүлэх.							
	Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах, салбарын байгууллагуудтай хамтран ажиллах	Хариу арга хэмжээний чадавхын хувь	80%	81.6%	82%	82.5%	84%	Улс, орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр
	Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавх, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийг нэмэгдүүлэх	Хариу арга хэмжээний чадавхын хувь	80%	82%	84%	85%	87%	Улс, орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр
2-р Үндсэн чиг үүрэг: Эмнэлгийн тусламж үйлчилгээ								
Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагуудад оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.	Анхан болон лавлагаа шатлалд шинэ дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан /AI/-ыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлж төвлөрлийг сааруулан, иргэдийг орон нутагтаа оношлох, эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх	Нэвтрүүлсэн технологийн тоо	-	1	1	1	1	Улс, орон нутгийн төсөв
	БОЭТ-ийн хавдарын оношилгоо эмчилгээ хяналт сэргийлэлтийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлж, хавдарыг эрт үед нь илрүүлэх, эмчлэх, нас баралтыг бууруулах	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо						Улс, орон нутгийн төсөв
	Яаралтай түргэн тусламжийн төвийг байгуулж, анхан болон лавлагаа шатлалын яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Яаралтай дуудлагад 20 минутын дотор очсон хувь	95%	95.1%	95.2%	95.3%	95.4%	Орон нутгийн төсөв
	Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх	Бэлтгэгдсэн ОНЭМА-ны тоо	-	10	20	30	40	Орон нутгийн төсөв
	Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн, хөгжүүлж, иргэдэд урт болон богино хугацаагаар цогц байдлаар тусламж үйлчилгээг үзүүлэх	Тусламж үйлчилгээний нэр, төрлийн тоо	2	3	4	5	6	Байгууллагын төсөв

	Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх	Үйл ажиллагааны тайлангийн хэрэгжилтийн хувь	80%	82%	84%	86%	88%	-
Зорилт 2. Эх, хүүхэд, зорилтот бүлгийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, тусламж үйлчилгээнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах	Эх хүүхдийн тусламж үйлчилгээний үзүүлэлт /промиллоор/	- Эхийн эндэгдэл-0 - Нялхсын эндэгдэл-8,3 - 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-10.2	-	-	-	- Эхийн эндэгдэл-0 - Нялхсын эндэгдэл-8,0 - 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-10.0	Улс, орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр
	Пренаталь оношилгооны төвийг байгуулж, нярайн эрт үеийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, нярайн эрт үеийн эндэгдлийг бууруулах	Хишгээ эмч	-	-	-	-	-	
	Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, цогц тусламж үйлчилгээг үзүүлэх.	Кабинетаар үзүүлсэн хүүхдийн тоо	10%	11%	12%	13%	15%	Орон нутгийн төсөв
Зорилт 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулна.	Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, тогтвортой үйл ажиллагааг хангах, хяналтыг сайжруулах.	ЭХНБ, эмийн сангуудын стандартын хэрэгжилт	82%	82.5%	83%	83.1%	83.5%	-
	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хувийг нэмэгдүүлж, засвар үйлчилгээг тогтмолжуулах	Ашиглалтын хувь	80%	83%	85%	86%	88%	Улс, орон нутгийн төсөв
	Эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулах	Агуулах баригдсан байна.		1				Улсын төсөв
Зорилт 4. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх.	Эрүүл мэндийн байгууллага болон иргэдийн эмийн хэрэглээнд хяналт хийж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилтийг судлах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	70%	73%	76%	80%	Байгууллагын төсөв
	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хяналтын цахим програм	Цахим системд хамрагдсан	92%	94%	96%	98%	100%	ЭЭХХЗГ

	нэвтрүүлэх.	ЭМБ-ын тоо						
3-р Үндсэн чиг үүрэг: Хүний нөөцийн хөгжил								
Зорилт 1. Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, хүний нөөцийн урт хугацааны төлөвлөлт хийх	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж,	Хэрэгжилтийн хувь	0	80%	85%	90%	95%	Байгууллагын төсөв
	Орон нутагт эмчлэх оношилох зорилгоор Үндэсний багуудыг ажиллуулж, хүний нөөцийг чадавхжуулах	Үндэсний багийн тоо, хамрагдсан эмч нарын тоо	18	20	22	25	30	Орон нутгийн төсөв
Зорилт 2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх	Эрүүл мэндийн байгууллага бүр эмч, эмнэлгийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, хяналтад авах, эмчлэн эрүүлжүүлэх.	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны хувь	94%	95%	96%	97%	98%	Орон нутгийн төсөв
	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85%	86%	87%	88%	89%	Байгууллагын төсөв
	“Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” батлагдсан.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	70%	80%	85%	90%	Орон нутгийн төсөв
4-р Үндсэн чиг үүрэг: Эрүүл мэндийн салбарын мэдээлэл, технологийн удирдлага								
Зорилт 1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамраан авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлэх эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх	“Эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын журам”-ыг хэрэгжүүлэх, хяналт тавих.	Хэрэгжилтийн хувь	10%	20%	30%	40%	50%	Байгууллагын төсөв
	Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.	Хэрэгжилтийн хувь	80%	82%	83%	84%	85%	Улс болон орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр
	Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэлд дата анализатор хийх чадавхыг нэмэгдүүлэх	Сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо	0	15	20	25	30	ЭМХТ, ЭМБ-ууд
	“Цахим эрүүл мэнд” нэгдсэн платформ хэрэгжүүлж, ажиллах	Цахим програмын	75%	80%	85%	90%	95%	ЭМЯ, ЦХЯ, ЭМХТ, ЭМБ-

		хэрэгжилтийн хувь						ууд
5-р Үндсэн чиг үүрэг: Эрүүл мэндийн санхүүжилт								
Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагыг санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, мэдээ тайланд хяналт тавих	Эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгө оруулалт болон дэд бүтцийг үе шаттай нэмэгдүүлж, үр ашгийг тооцох, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх	Хөрөнгө оруулалтын тоо	10	12	14	15	16	Улс болон орон нутгийн төсөв
	Эрүүл мэндийн даатгалын үр ашгийг сайжруулж гүйцэтгэлийн санхүүжилтийг тусламж үйлчилгээний бүх төрөлд нэвтрүүлэх	Нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь	8	9	10	11	12	ЭМДЕГ, ЭМДХ, ЭМБ-ууд
6-р Үндсэн чиг үүрэг: Эрүүл мэндийн салбарын удирдлагын манлайлал, ил тод байдал								
Зорилт 1 Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт ил тод байдлыг ханган, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулах.	Эрүүл мэндийн байгууллагуудтай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулж, дүгнэн ажиллах.	Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь	88.3%	88.5%	86%	87%	88%	-
	Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх.	Нэвтрүүлсэн байгууллагын тоо	4	9	10	11	12	Орон нутгийн төсөв, байгууллагын төсөв
	Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо	2	2	2	2	2	Орон нутгийн төсөв
	Эрүүл мэндийн байгууллагуудад иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг цахим болон OR, Google форм ашиглан хийх, дүгнэх	Үнэлгээний хувь	74.4%	75%	78%	80%	85%	Байгууллагын төсөв
	Аймаг, орон нутгийн батлан хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, дэд хөтөлбөрүүдийг иргэд олон нийтэд хүргэх, зохион байгуулж буй үйл ажиллагааг иргэд олон сурталчлах	Сурталчилсан тоо	5	7	9	11	13	-
	Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг ил тод цахимжуулах,	Цахимжуулсан үйлчилгээний	2	3	4	5	6	ЭМЯ, ЭМХТ, Орон нутгийн

	хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах	тоо						төсөв, байгууллагын төсөв
	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүх хэлбэрээр авч, шийдвэрлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	100%	100%	100%	